

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭЧЛЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЕИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТИЙН ХАРЬЦААНЫ АСУУДАЛД

Ш. Бат-Очир

1. Үйлдвэрлэлийн харьцааны шинж чанар

Тогтмол, тусгай хил хязгаар, нутаг дэвсгэртэй, ижил нэг хэл бичиг, соёл боловсрол, ахуй, зан заншил дээр үндэслэн тогтворжинж материал баялгийг бүтээн, оюун ухааны эрдэнэсийг бүрэлдүүлдэг хүмүүсийн нэгдлийг хүний нийгэм гэж нэрлэдэг. Түүний материал баялаг, оюун ухааны эрдэнэсийг бүтээн босгодог хүчийг нь нийгмийн үйлдвэрлэхүй хүч гэдэг. Үүнд нь бие хүмүүс, үйлдвэр, аж ахуй, эд материал, үйлдвэрийн зэвсэг багаж бүтд багтдаг юм. Хүмүүс нийгмийн материал баялгийг бүтээх оюун ухааны эрдэнэсийг бүрэлдүүлэхдээ хэзээ ч ганц нэгээрээ ажилладаггүй, үргэлж хамтран хоршиж ажилладаг юм. Ийнхүү бүтээн босгох үйл ажиллагааны хөдөлгөөний явцад хүмүүсийн хооронд үүсэн гарч байдаг олон янзын хэлхээ холбоо, харилцааны цогцолборыг нийгмийн үйлдвэрлэлийн харьцаа гэж томъёолдог юм. Жишээ нь монгол улсын бүх материал баялаг, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, соёл, урлаг шинжлэх ухааныг хөгжүүлэх, шашин бурхан бүтэх хууль цааз гаргах, худалдаа арилжаа хийх, эх орноо хамгаалах гэх зэрэг олон янзын үйл ажиллагаанд манай малчин, ажилчин сэхээтний хооронд үргэлжлэн гарч байдаг харилцаа холбоо нь манай улсын үйлдвэрлэлийн харьцааг үүсгэж байгаа нь тэр юм. Ерөнхийд нь дүгнэвэл: үйлдвэрлэлийн харьцаа нь улс нийгмийн үйлдвэрийн багаж зэвсгийг өмчлөх, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хуваарилах, хуваарилсныг эзэмшин хэрэглэх үйл ажиллагааны арга хэлбэрт хүмүүсийн хооронд гардаг харилцаа холбоо юм.

Одоо манайд нийгмийн шинжлэх ухааны онол, үзэл бодол, ухагдахуун бүхнийг нь хоосон коммунист ухуулга гэж буруушаах бас нэг хэтрэлт, туйлшрал гараад нийгмийн шинжлэх ухааныг бүхэлд нь үгүйсгэх хандлага ажиглагдах болж байна. Ийм ойлголт «онол» нь нийгмийн шинжлэх ухааны хөгжил, судалгаа манайд цаг үеийнхээ шаардлагаас хоцрогдож байгаа боловч ИШУ-ны үндсэн асуудлыг мушгин гуйвуулж байгаагийн илрэл юм. Ийм үгүйсгэлд нийгмийн үйлдвэрлэлийн харьцааны тухай онолын ойлголт нэг адил хамаарагдаж байна.

Нийгмийн үйлдвэрлэлийн харьцааны тухай асуудал бол зөвхөн ганц коммунистуудын сургаал биш, улс нийгэм бүхний амьдралын бодит зүй тогтолын диалектик уялдаа холбоог яг байгаагаар нь тайлбарладаг нийтлэг онол. Үйлдвэрлэлийн харьцааны тухай асуудлыг яаж ойлгож түүнд хэрхэн хандсанаас нийгмийн бүхий л амьдралын хувь заяаг шийдвэрлэдэг юм. Тухайлбал монгол орны шинэхэн үеийн түүхэн үйл явдлуудаас жишээ авч болох юм. Манж хятадын боолчлолоос салсны дараа үе, 1921—1990 оны хоорондох үе 1990 оноос хойш онөө үеийн нийгмийн зөрчил эдийн засгийн хоцрогдол, гажуудал, хямралууд бодит зүй тогтоолыг

захиргааны аргаар буюу хүмүүсийн санаа зоригоор зүтгэж тулган шийдвэрлэж байсны гай юм.

Хүний нийгэм бол эцэстээ очоод байгаль дэлхийн хувьсгал, хөгжлөөр үүсдэг, түүний биет бүтээгдэхүүн юм. Байгаль дэлхийн хувьсал өөрчлөлт нь өөрийн дотоодын маш нарийн бодит хууль зүйн дагуу явагддаг бөгөөд түүнтэй яг адил хүний нийгэм бас л хэнээс ч, юунаас ч эс хамаарах бодит хууль, зүйгээр хөгжин өөрчлөгддөг юм. Байгаль дэлхийн нэг адил хүний нийгэмд зүсэн зүйлийн олон төрлийн бодит хууль зүй тогтоол үйлчилж байдаг ажээ. Эдгээрийн нэг нь нийгмийн үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчний шинж чанар, хөгжлийн түвшингтэй нь яг тохирч байх гэсэн эдийн засгийн түгээмэл бодит хууль байдаг ажээ.

Үйлдвэрлэлийн харьцаа нь үйлдвэрлэх хүчний шинж чанар, хөгжлийн түвшингтэй тохирч байх гэдэг бол нийгмийн улс төрийн систем, засаг төрийн хууль дүрэм, олон нийтийн намуудын хоорондын харьцаа, тэдний үйл ажил үзэл суртал, гаргаж буй шийдвэр, явуулж буй ухуулга, нийгмийн ёс суртахуун, шашин мөргөл, зан заншил хөдөлмөр зохион байгуулалт, хүмүүжил боловсрол гэх зэрэг албан ба амины бүхий л үйл ажиллагаа, хөдөлгөөн нь нийгмийн материаллаг үйлдвэрийг баяжуулах оюун ухааныг, хөгжөөн дээшлүүлэх зэрэг бүхий л дэвшилтийг ямагт урагш нь хурдан түлхэн ахиулан урамшуулагч хүч болж чадаж байваас сая үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүний шинж чанар, шаардлагад тохирч байгаа нь тэр ажээ. Харин дээр үед манайд хувийн аж ахуйтны малын тоо толгойг хурдан өсгөн нэмэгдүүлэх эдийн засгийн шаардлагатай байх үед малын тоо толгой олшрох тутам малын толгой бүрээс улсад төлөх албан оногдол үүргийн хэмжээ малын тоо толгойн өсөлтийг дагуулан нэмэгдүүлээд байдаг байсан, бас нүүдлийн хувийн мал аж ахуйтны малын тоо ихээр нэмэгдэж аж ахуй томорч ирэхэд малчид малаа ганц өөрсдийн хүчээр маллаж дийлэхгүй болоход хөлсний хөдөлмөрийг зайлшгүй хэрэглэх болоход тэднийг нударган баячууд хөрөнгөтний хэсэг гэж хавчин хязгаарлаж устгаж байсан зэрэг харьцаа нь тухайн үеийн үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчний шинж чанарт тохирч байх эдийн засгийн хууль дүрэм нь үйлдвэрлэх хүчний хөгжлийг хорлон буснуулагч болон хувирдаг байсан олон жишээг бид манай аж ахуйн түүхнээс мэднэ. Үүнээс ойлгоход түүхийн аль ч үед улс нийгэм бүхэнд тэдний хөгжил дэвшил, уналт нуралтыг тухайн үеийн үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харьцаа хоорондын уялдаа тохиролцоо жолоодож байдаг зүй тогтоолтой байдаг байсан нь үнэн. Үүнээс Монгол нийгмийн үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчний хоорондын харьцаа ангид өөр зүйл биш болох нь бас мэдээжээ!

Монгол орны одоогийн нийгэм эдийн засгийн байдлыг үнэн зөвөөр ойлгохын тулд юуны өмнө өнөөгийн үйлдвэрлэлийн харьцааны шинж чанарыг судлах нь гол чиглэл болох нь зайлшгүй.

Хүн төрөлхтөний хөгжил дэвшлийн урт удаан хугацааны түүх бол нийгмийн үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харьцаа хоёрын хоорондын уялдаа холбоо, тохиролцоо, зөрчил гажуудлын өөрчлөлтийн түүх байжээ. Харин нийгмийн хөгжлийн нэг онцлог нь аль ч улс гүрэнд түүхийн ямарч үед үйлдвэр-

лэлийн харьцаа нь үйлдвэрлэх хүчнийхээ шинэ чанарт зуун хувь үргэлж мөнх тохирч байдаггүй, нэг үе зөрчилдөж нөгөө үед зохицолдож дараа нь бүрмөсөн зөрчилдөж тохирохоо бүрэн больж нийгмийн донсолгоон болж шинэ үйлдвэрлэлийн харьцаа тогтнон үйлдвэрлэхүй хүчээ хөгжүүлж эхэлдэг юм байна.

Монгол нийгэм түүхэн үеийнхээ турш хөгжлийн нэг шатнаас нөгөөд шилжин өөрчлөгдөж ирсэн нь түүний тухайн үеийн үйлдвэрлэлийн харьцаа нь үйлдвэрлэх хүчний шинэ чанарт ямар нэг хэмжээгээр уялдаа тохирч, заримдаа зөрчилдөн хувирч байдаг байсан баталгаа бий билээ. Манай орны үйлдвэрлэлийн харьцаа нь хамгийн илэрхийгээр үйлдвэрлэх хүчинтэйгээ гүнзгий зөрчилд ороод түүний хөгжлийн чөдөр тээг нь болж байсны баримтыг 1900 он, 1920, 1990 онуудын үйл явдлаар батлан тодорхойлж болох юм.

1900 оны эхээр монол орон манж хятадын олон зуун жилийн дарлагдлын талхинаас мултарч прэхэд хятад, орос хоёр гүрний хуйвалдаанаар тэдний нөлөө хяналтын дор автономит гэдэг засаг бүхий улс байгуулж колоничлогчдын тоглоомын улс буй болгосноор үйлдвэрлэлийн харьцаа нь монгол үндэсний үйлдвэрлэх хүч-эдийн засгийн сэргэн маандах их хөгжлийн замыг боож тагласан юм. Энэ үеийн монгол орны үйлдвэрлэх хүч үйлдвэрлэлийн харьцааны хоорондын гүнзгий зөрчил нь шинээр тогтоосон автономит засаг монгол орны материаллаг үйлдвэр-эдийн засгийн хятад оросын худалдааны капиталын гарт атгуулсан тэр үеийн засаг төрийн бодлого, хууль цааз, ёс суртахууны үзэл бодол, шашин мөргөл бүгдээр тэдний ашиг тусад зохицож байв. Тэрхүү худалдааны капитал нь монголын эдийн засгийн зөвхөн хэрэгцээний чиглэлтэй дан өөрсдийн хөдөө аж ахуйн түүхийн эдийн бэлтгэл газар болгон барих болсноор үйлдвэрлэлийн харьцааны сөрөг нөлөө нь илэрч байв.

1920-иод оны үеэр дэлхий дахины болон монголын ард түмний ачаар эх орноо том гүрнүүдийн колоничлолоос чөлөөлөн дэлхий дахины нийтлэг ардчилсан олон хэвшилт чөлөөт таваарын үйлдвэрийн хөгжлийн замаар явж хөгжих болоход Зөвлөлт холбоот улсад тогтсон хиймэл социализмын үйлдвэрлэлийн харьцааг манай оронд хуулбарлан тогтоож монгол улсын үйлдвэрлэх хүч-эдийн засгийн хөгжлийн дэлхийн дахины орчин үеийн өндөр хөгжлийн түвшинд хүрэх байсан замыг бас таглан боогдуулаад одоо далаад жилийн нүүр үзэж явна. Энэ үеийн манай орны үйлдвэрлэх хүч үйлдвэрлэлийн харьцааны хоорондын гүнзгий зөрчил нь монголын эдийн засаг Зөвлөлт холбоот улсын төрийн монопольт эдийн засгийн загвар болоод монгол орон зөвхөн хэрэглэгч чиглэлтэй, харьяат гүрний зах зээл болон хувирснаар илэрч байжээ.

1990-ээд оны үе гэхэд монгол орон хөрөнгөтний биш хөгжлийн зам гэгчээр хооцөлдөн явсаар оновчтой материал техник, шинэчлэх ухааны бодит үндэс суурийг босгоогүй атлаа социализмыг бүрэн төгс байгуулж байна, гэж тунхаглан зарлаж байсан болэвч үнэн хэрэг дээрээ бусдын хараат хэвээр орчин үеийн, бие даасан эдийн засагтай улс болж ча-

даагүй, үйлдвэрлэлийн харьцаа нь гаднын дууриамал өнгөц талын хуурмаг социалист үзэмжийн үйлдвэрлэлийн харьцаатай орон байв. Тийм үйлдвэрлэлийн харьцаа нь засаг төрийн хэлбэр, явуулж ирсэн бодлого гаргаж байсан хууль дүрэм, нам олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаа, ёс суртахуун, суртал нэвтрүүлэг, урлаг соёл, нийгмийн хөдөлмөр зохион байгуулалт, хүмүүжил боловсролын бүхий л арга хэлбэр утга агуулгаар илэрч байв.

Монгол нийгмийн эдүгээгийн үйлдвэрлэлийн харьцааны шинэ чанарын тухай тодорхойлно гэдэг бол өнгөрсөн далаад жилд нийгмийн амьдрал, эдийн засагт гаргасан алдаагаа засаж нийгмээ ирээдүйд шинэчлэн хөгжүүлэхэд одоогийн манай үйлдвэрлэлийн харьцаа чухам яаж, юугаар саад болж байгаа тухай, түүнийг ямар арга замаар гэтлэхийг тодорхойлох гэсэн хэрэг ажээ.

1990-ээд оны өмнөх үед нэг талаас манай тэргүүний ардчилсан социалист хэмээгдэн нэрлэгдэж байсан төр засгаас авахуулаад бусад бүх давхаргууд: нөгөө талаас бүдүүлэг хоцролгүй ахуй амьдрал хоёрын хоорондын харшлаар үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харьцааны хоорондох зөрчил тодорч байсан юм. Өнгөрсөн 70-аад жилийн турш социализмын материал техникийн баазыг байгуулж байна гэж хийсвэрлэн тунхаглаж байсантайгаа адилаар одоо жинхэнэ ардчилсан хүчирхэг шинэ нийгмийг байгуулж байна гэж бодит материал үйлдвэрийн үндэс тулгуургүй тунхаглаж байгаа ба үүний хажуугаар урьд үеийнхээ бүтээж босгосон үйлдвэрлэх хүчийг устгаад түүний үлдээсэн хоосон зайд нь дан ганц нийгэм улс төрийн шинэ давхарга болох олон намууд, парламент, ерөнхийлөгчээр толгойлуулсан билэг тэмдгийн засаг төр зэрэг тогтноод байгаагаар монголын одоогийн үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харьцааны зөрчил илэрч байна. Үүний улмаас 1990-ээд оноос хойш «шинэ ардчилалын» үндэс тогтнож байгаа монгол улсын одоогийн үйлдвэрлэлийн харьцаа нь үйлдвэрлэх хүчнийхээ урагшлан дэвшигч хөгжих хөдөлгөөний тээг болж эхэлж байна. Манай ниймэрхүү бүтэмжгүй, сөрөг үйлдвэрлэлийн харьцаа, үйлдвэрлэх хүчний хөгжлийг яаж саатуулж байгаагийн одоогийн зарим нэг жишээ баримтыг дурдвал ойлгомжтой болох бизээ.

Нэг. Тус орны эдийн засгийн хөгжилд манай одоогийн үйлдвэрлэлийн харьцааны зарим нэг сөрөг нөлөө

Улс нийгмийн эдийн засгийн хөгжилд дэвшил яаж хэрэгжих нь тухайн үеийн үйлдвэрлэлийн харьцаанаас бүрэн хараат байдаг нь амьдралаар батлагдсан эцсийн үнэн билээ. Монгол улсын одоогийн эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийг эхэлсэн жинхэнэ ардчилал гэгдэх одоогийн манай үйлдвэрлэлийн шинэ харьцаа маань үйлдвэрлэх хүчээ гүнзгий хямралд түлхэн оруулсан хүчин зүйл болон хувирсан байна. Одоогийн манай шинэ үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчний хөгжлийг яаж хойш татай сөргөөр нөлөөлж байгаа нь дараахь үйл явдлуудаас харагдаж байна Үүнд:

1. 1990-ээд оноос монгол улсын эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөг удирдлагыг коммунист ёс гэж нүд үзүүрлэн хараан зүхэж устгаад нийгмийн үйлдвэрлэх хүчийг төр засгийн удирдлага, зохицуулалтгүй болгон зоргонд нь тавьжээ.

Үүний балагаар одоо улсын эдийн засаг хэтийн нарийн чиглэл, тооцоо, биетэй үнэмшигдэх нийгмийг урагш нь босгон дайчилж чадахуйц эдийн засгийн ирээдүйн төлөвлөгөө баримжаагүй тэмтэрч явна. Тэгээд монгол нийгмийн эдийн засгийн толгой нь доошоо хөл нь дээшээ харсан юм шиг, эх адаг нь мэдэгдэхгүй эмх замбараагүй байдалтай болоод байна. Үүнд шинэ ардчилсан үйлдвэрлэлийн харьцаа маань үйлдвэрлэх хүчээ сэргээн босгох нь ч байтугай устгах замд оруулаад байна.

2. Нэгдсэн, үндэстэй өндийж байсан улс ардын аж ахуйн салбаруудыг жинхэнэ эзэнтэй болгож байна гэдэг нэрийдлээр бутраан тарааж устгаснаар одоо манайд урьдынх шиг хоорондоо нягт холбоотой нэгдмэл хөдөө аж ахуй, аж үйлдвэр, тээвэр холбоо, санхүүгийн систем алга болж бүгдээрээ ёс төдий олон эзний нэр дээр эзэнгүйдэн үрэгдэж байна. Улс ардын аж ахуйн салбаруудыг хооронд нь шинэ арга замаар уялдуулан зохицуулахын оронд аж ахуйн салбаруудыг хооронд нь сөргөлдүүлж тавих болсноор шинэ үйлдвэрлэлийн харьцааны сөрөг ажиглагаа нь илэрч байна.

3. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хоорондын зохицсон уялдаатай харилцааг тас цохиж аж үйлдвэрийг хөдөө аж ахуйн түүхий эдээр, хөдөө аж ахуйг материал техникээр тус бүр хангадаг байсан эдийн засгийн гол хэлхээ холбоог устгасан нь одоогийн манай шинэ үйлдвэрлэлийн харьцааны маргацгүй том нүгэл нь гарцаагүй мөн.

4. Монгол улс орчин цагийн дэлхий дахины нийтлэг хөгжлийн замд олон хэвшилт өмчийг хөгжүүлнэ гэж тунхаглаад үнэн хэрэг дээрээ зөвхөн ганц хувийн жижиг өмчөөр түрээ барьж улс хоршооллын өмчийг төр засгийн шийдвэрээр тарааж байгаа нь шинэ үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчний хөгжлийг зуун жилээр ухрааж байгаа хэрэг гарцаагүй мөн.

5. Өмч хувьчлал гэдэг монгол нийгэмд авсаар бүрэн ойлгогдохгүй, бусад орны үйл явдлыг механикаар дууриаж яаран сандарч хуулбарлан бүгдийг өмчтэй болгож байна гэж хүн бүхэнд арван мянган төгрөгийн хувь хүртээсэн нь хүмүүсийг илэрхий хуурсан, хүүхдийн гэнэн үйлдэл мэт хэрэг болсон юм.

6. Олон хэвшилт, чөлөөт таваарын үйлдвэрийг хөгжүүлэх цорын ганц зөв арга ухааныг жижиг худалдаа, дамын наймаагаар сольсон нь манай ардчилсан шинэ үйлдвэрлэлийг харьцааны нэг гол алдаа нь байгаа.

7. Юун юунаас урьд олон өмчийн чөлөөт таваар үйлдвэрлэлийг хөгжүүлснээр түүний гол үр дүн болон үүсдэг чөлөөт үнийг дамын наймааны монополь үнээр сольсон нь одоогийн манай үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчээ нураах ард түмнийг ядууруулах нэг хэрэгсэл болж байна.

8. Засаг төрийн эрх баригчдын шийдвэрээр улсын мөнгөн сан хөрөнгийг хувийн өмчийг дэмжих нэрийдлээр дан ганц жижиг худалдаачдад тараан өгсөн нь нийт үйлдвэрлэх хүчин хөл дээрээ тогтох санхүүгийн үндэсгүй болгосон нь тодорхой болоод байна.

9. Хот хөдөөгийн нэгдмэл өмчийн системийг задлан тарааснаар аж үйлдвэр хөдөө аж ахуй хоёрын хоорондын эдийн засгийн харьцаа тасарч аж үйлдвэр түүхий эдийн баазгүй.

хөдөө аж ахуй материал техникийн хангамжгүй болоод үйлдвэрийн харьцаа маань өөрөө түших тулгуургүй болоод байна.

10. Засаг төрийн бодлогоор эх орны аж үйлдвэр хаагдаж худалдаа зөвхөн хувийн гадаадын жижиг бараа таваарын ганзагын наймаа болон хувирснаар манай нийгмийн материаллаг баялгийг бүтээх түүнийг хэрэглэх хоёрын хоорондын амин холбоо тасарч үйлдвэрлэх хүч хямралдах нэг гол нөхцөл бүрэлдсэн зэрэг олон сөрөг явдлуудаар одоогийн манай ардчилсан хэмээгдэх үйлдвэрлэлийн шинэ харьцаа эдийн засгийн амьдралд үлэмж их сөрөг нөлөөг үзүүлж байна. Үйлдвэрлэлийн харьцааны дээр дурьдсан зөрчлүүдийн шууд үр дагавар болж манай эдийн засгийн амьдралд зүйл бүрийн харш, аюул бүхий үйл явдлууд үүсэн гарч ирэх болсон байна. Жишээлбэл үүнд: ажилгүйдэл гэдэг монголын түүхнээ үзэгдээгүй нийгмийн шинэ дарамт нөмрөх болсон; Ард түмэн амьдралаараа нийтдээ доройтон, бараг ядуурал хоосролд орох шинжтэй болж байгаа; (монгол орон хоосролд дийлэгдэж байсан удаагүй гэдгийг энд зориуд тэмдэглэх хэрэгтэй байна). Бас хандив хэмээгдэх нийгмийн хэмжээний бадар барилт буюу «боловсон» гуйлга, эсхүүл хямд, бэлнээр амьдрах гэсэн шинээр үйлдвэрлэн бүтээхээс булзааруулсан, бусдын хүчийг хожих ёс одоо манайд өргөн дэлгэрсэн, ард түмний худалдан авах чадвар үлэмж их буурсан, мөн материал баялгийн үйлдвэр хүмүүсийн бодит хэрэгцээ хоёрын хоорондын гүнзгий зөрчилд орсон явдал үүний хажуугаар америкийн доллар мэт гадаадын мөнгөн тэмдэгт үндэсний мөнгөн тэмдэгтийг дотоодын зах зээлээс шахан гаргах болж буй хандлага, үндэсний нэгдсэн эдийн засаг нурик унаж байгаагийн улмаас засаг төр маань өөрөө зөвхөн дамын худалдаан дээр түшиглэхээс өөр аргагүй болж ард түмний ашиг сонирхолыг хохироож байгаа зэрэг монголд зүсэн зүйлийн сөрөг харьцаа тогтнож нийгмийг бүхэлд нь эдийн засгийн хямралд оруулаад байна.

Хоёр. Монгол улсын соёл боловсрол, шинжлэх ухааны хөгжлийг саатуулж буй үйлдвэрлэлийн харьцааны зарим сөрөг нөлөө

Манай ардын хувьсгалын үйлдсэн нэг том буян бол ард түмэнд орчин үеийн төрөл бүрийн шатны үнэ төлбөргүй мэргэжил боловсрол, шинжлэх ухаан, соёл боловсролын боловсон хүчний бүхэл бүтэн эрдэмтдийн армийг төрүүлэн бойжуулсан явдал юм. Үүний ачаар монгол улс орчин цагийн соёл боловсрол, шинжлэх ухааны дотоод хүчин чадлын хувьд 1990-ээд оны үеийг хүртэл дэлхий дахинд чамлашгүй өндөрлөгт хүрсэн байв. Харин манай оронд эдүгээ шинээр тогтносон ардчилсан хэмээгдэх одоогийн үйлдвэрлэлийн харьцааны сөрөг нөлөө соёл боловсрол, шинжлэх ухааны хөгжилд бас саад тоггор учруулах болоод байна. Үүнд зарим нэг жишээг дурдвал:

1. Хөрөнгө мөнгөний хомсдол мөн төр засгийн боловсруулсан тодорхой бодлогогүй байгаа учраас шинжлэх ухааныг нийгмийн үйлдвэрлэх хүч болтол хөгжүүлж чадахгүй нэр төдий болоход хүрч байна. Энэ нь манайд одоо чухал ямар төрлийн шинжлэх ухааныг түрүүлэн, түргэн хөгжүүлэх нь үл мэдэгдэх, шинжлэх ухааны ололт нээлтийг амьдралд нэвтрүүлэхгүй байгаа дэлхийн шинжлэх ухааны ололтыг хүртэж

чадахгүй байгаа шинжлэх ухааны үүднээс эх орноо судлан шинжлэх эрдэмтэн мэргэжилтэн нарыг дэмжин урамшуулах үйл явдал зогсонги байдалд орсноор тодорч байна.

Манай дээд дунд боловсролын программ, сургалтыг өөрийн амьдралд уялдуулаагүй, боловсролын системийг орчин үеийн шинэ нөхцөлд зохицуулан шинэчлээгүй. түүний хөгжлийн түвшин нь 1990 оны өмнөх үеийнхээс үлэмж буурахад хүрч байгаа.

3. Зөвхөн мөнгө хожих наймаа, арилжаа хөөцөлдсөн, чанаргүй, хуурамч янз бүрийн нэр гүншинтай олон хиймэл дээд сургууль байгуулагдаад байна. Үүнээс үүдэн дээд боловсролын өгөөж чанар доройтож нэр хүнд нь унаж, үй түмэн дууриамал дээд боловсролтон, мэргэжилтэн олширч сэхээтний давхаргат ялзрал буй болж эхэлж байна.

4. Улс, ард түмний үнэт их хөрөнгөөр бэлтгэж бүрэлдүүлсэн өндөр, ховор мэргэжлийн сэхээтэн дамын жижиг худалдаа наймаанд олноороо татагдан орж манай шинжлэх ухаан, соёл боловсролд асар их гарз хохирлыг учруулж байна.

5. Монгол орны өвөрмөц байдал эдийн засгийн ядуу дорой байдлыг үл ойшоон хөгжилтэй, тэргүүний орнуудыг дууриаж бүх соёл боловсрол, шинжлэх ухааны үйл хэргийг зах зээлийн мөнгөн үнэлгээнд оруулан соёл боловсрол, шинжлэх ухааны үйл явдлыг цөөхөн баячууд өмч болгож монгол нийгмийг удахгүй XIII зууны харанхуй бүдүүлэг байдалд шилжүүлэх бэлтгэлийг хийж байна. Үнэ төлбөргүй боловсрол, шинжлэх ухааны өгөөж нь одоогийн дэлхий дахины нийтлэг зүйл биш боловч монгол орныг дундад зууны харанхуйгаас ангижруулсан соёлт улс болгосон нь ганц ардын хувьсгалын үнэлж баршгүй гавьяа юм. Үүнийг нийм цаг үед яаран сандарч устгана гэдэг бол ард түмний эсрэг хандсан гэмт хэрэг мөн.

6. Одоогийн засаг төрийн алсын хараат бодлогогүйгээс болж үндэсний хэл бичгээ хоёрдмол болгож хоосон ашиггүй маргаан дэгдээн олон түмний санаа сэтгэлийг үймүүлж байгаа нь одоогийн үйлдвэрлэлийн харьцааны бас нэг гажуудлын үр дагавар мөн.

7. Залуу үе — эх орны прээдүйг хүмүүжүүлэх их үйл ажил бүрмөсөн хаагдсан нь одоогийн үйлдвэрлэлийн харьцааны нэг том сөрөг үйлдэл мөн. Үүний шууд үр дагавар болсон хулгай дээрэм, хүчирхийлэл, согтуурал зэрэг хачин, бүдүүлэг хүнлэг бус бараг хагас зэрлэг харьцаа хэвийн болж нийгмийн дунд дэлгэрэх болж байна.

8. Монголын хөдөө нутаг орчин үеийн шинжлэх ухаан, соёл боловсролыг үр өгөөжийг хүртэж чадахгүй болж тэднийг улмаар эрт дээр үеийн харанхуй амьдрал руу шахах болж байна. Энэ нь сонин хэвлэл, кино урлаг үзвэр, шинжлэх ухааны бодит мэдлэгээр хөдөө нутаг соёлын өлсгөлөн болсон, сургууль боловсролын үнэ төлбөрийг ардууд дийлэхгүй болсон, цэцэрлэг ясли хаагдсан, сургууль клуб улаан булан зэрэг соёлын газар бугарч тарсан бага насны хүмүүсийг бэлчээрийн малын салшгүй дагуул болгон хатааж байгаа зэрэг үйл явдлаар тодорч байна.

9. Нэгэнт манай орны соёл боловсрол шинжлэх ухааны үйл ажиллагаа, зохион байгуулалт ийм болсон учраас дэлхий дахины шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэн хүртэх, гадаадын эрдэмтэдтэй хамтран ажиллах зэрэг асуудал ор нэр, хувь хүмүүсийн алдар цолын хоорондын харьцаанаас хэтэрч чадахгүй болсон байна. Төр засгийн шинжлэх ухаан соёл боловсролын бодлого ийм шинж чанартай байгаа болохоор манай одоогийн үйлдвэрлэлийн харьцаа маань шинжлэх ухаан соёл боловсролыг хөгжүүлэгч хүчин зүйл болохоосоо харин түүнд сөрөг нөлөө үзүүлэх болж байна.

Гурав. Оюун ухаан, нийгмийн харьцаан дахь үйлдвэрлэлийн харьцааны сөрөг нөлөө

Энэ асуудлаар одоогийн манай үйлдвэрлэлийн харьцааны гажуудлаас үндэслэн манай хүмүүсийн оюун ухаан, зан заншил, хэв ёсонд ямар буруу үзэгдэл ажиглагдаж байгаа тухай яригдах болно.

Аль ч улс гүрэн нийгэм бүхэнд дэвшилттэй буюу эсхүүл сөрөг нөлөөтэй үйлдвэрлэлийн харьцаа тогтоосон байвал хүмүүсийн оюун ухаан, зан заншил, ёс суртахуун иймэрхүү байдаг ажээ. Манай орны одоогийн хүмүүсийн оюун ухаан, зан заншилд янз бүрийн сөрөг үзэгдэл их ажиглагдах болж байна. Үүнд зарим нэгийг жишээ болгон дурдъя.

1. Монгол хүмүүс бидэнд бат тогтносон ирээдүйн нэгдмэл итгэл үнэмшил бүрэн тогтнож чаддаггүй болсон байна. Үүний үндсэн шалтгаан нь манай төр, засаг, намуудын үзэл бодол, бодлого шийдвэр, хууль дүрэм нь нарийн хуульчлан тогтоодог боловч тэр нь хэрэгжин биелэгдэж зүй ёсоор үйлчилж чаддаггүйд оршиж байна. Жишээ нь манай шинэ засаг төр маань маш олон сайхан хууль батлан гаргасан боловч одоо нийгмийн амьдралд хэрэгжин гийгүүлж үр ашгаа өгч ард түмний нийтлэг эрх ашгийг хамгаалж байгаа зүйл тун бага байна. Үүнээс болж төрийн хууль, шийдвэрт түүний ирээдүйд хандах итгэл үнэмшил төрж чаддаггүй байна.

2. Монгол хүмүүс бидний оюун ухаанд бат суурьтай жинхэнэ эх оронч ухамсар бүрэн тогтнож чаддаггүй байна. Үүний улмаас 1921 оны ардын хувьсгалын үр дүн буруу эргэсэн, эх орны өнгөрсөн 70 жилийн хөгжлийн явц гажуудагдан саатсан, 1990-ээд оны ардчиллыг урвуулан гуйвуулсан зэрэг үйл явдлуудын эсрэг тууштай, эх оронч хамсар тэмцэл тун их дутагдаж ирсэн юм. Үүний гол шалтгаан нь Монгол улсад эрт дээр үеэс тогтнож байсан үйлдвэрлэлийн харьцаа нь ямагт голдуу гадаадын том гүрнүүдийн эрх ашигт захирагдан тэдний эрхшээлд үйлчилдэг байсан явдал юм.

3. Монгол хүмүүс бид нарт төлөв, тогтвортой, хөдөлшгүй оюун ухааны байр суурь тэр болгон байж чаддаггүй учраас аль нэг үйл явдлыг үргэлж нэг тийш нь дэгдүүлэн хэтрүүлж туйлшруулан ойлгож хуйларч давхидаг болсон нь нийтлэг заншил болсон байна. Ийм гажиг зан хөдөлгөөн нь манай нийгмийн соёлын ерөнхий түвшин, нүүдэлчдийн иргэншилтэй сурвалж нэгтэй байж болох юм. Заримдаа энэ тэр үзэгдэл юмыг огт ул үндэсгүй, хий хоосон тэнгэрт тулгал шагшин магтах, тэгснээ удалгүй түүнийгээ газар дор ортол муулах болсон заншлаар ерөнхийдөө энэ сөрөг хэв заншил илэрч байна. Жишээ нь олон жилийн турш ардын үйлдвэрлэлийн

хоршооллын (ходоо аж ахуйн нэгдлийн) өмчийг дээд зэргээр үнэлэн дэмжиж хувийн өмчийн хэлбэр бүхнийг үгүйсгэн харааж муулдаг байсан төр засаг маань одоо гэв гэнэт хоршооллын өмчийг үзэн ядаж тараан бутрааж жижиг хувийн өмчийг бурханчлан шүтэх болж байна. Бас тун саяхан болтол манайд бурхан шашныг нийгэм даяар хар тамхи гэж дайран довтолж сүйтгэн лам хувраг нарыг аймаглан устгаж байсан билээ. Гэтэл одоо шашныг мандуулах асуудлыг төрийн бодлогын зэрэгт аваачиж нийгмийн үлэмж их хүч чармайлт, хөрөнгө мөнгө зарцуулан эдийн засгаа сэргээн босгох бодлогын дэргүүр тавихад хүрч байгаа зэрэг олон янзын туйлшралыг дурдаж болох ажээ. Бидний оюун ухаан зан заншил ийм сөрөг үзэгдэл нь эх орныхоо жинхэнэ бодит амьдралын гүнзгий мэдлэгтэй болж чаддаггүй, үргэлж юм бүхэнд хөнгөн хийсвэр хандаж байдагтай бас шууд холбоотой байж болох юм.

4. Манай одоогийн үйлдвэрлэлийн харьцааны нийгмийн оюун ухаан, зан заншилд учруулж байгаа өөр нэг сөрөг нөлөө бол бид нар ямар ч тодорхой судалгаа, тооцоогүй, бараг харж үзсэн бүхнээ шууд дууриан хуулбарлаж, түүнийгээ огт таарч тохирохгүй манай амьдралд тулган нэвтрүүлэхийг чармайдаг болсон заншил юм. Үүний илрэл нь: Зөвлөлт Холбоот улсын социализмыг хуулбарласан одоо манайд ардчилал гэж нэрлэгдэж байгаа, 1990-ээд оны эхэлсэн нийгэм эдийн засгийн үймээн, өмч хувьчлал гэх зэрэг олон үйл хэргүүдээр наад зах нь тодорч байна. Манай үйлдвэрлэлийн харьцааны ийм гажуудлын үндсэн шалтгаан нь бидний сэтгэхүйн хөгжил тэр болгон гүйцэд боловсронгуй болж чаддаг материаллаг үндэслэлгүй байдаг монголын өвөрмөц ахуй бололтой.

5. Нийгмийн амьдралын үйл ажиллагаа бүхэнд юу юунаас урьд шинээр бүтээн босгохыг сэтгэхийн оронд ямагт бэлэн юмыг шүүрэн авч ашиглахыг гол болгодог заншил манай үйлдвэрлэлийн харьцааны одоогийн гол нэг шинж болсон байна. Үүний үндсэн шалтгаан нь ялангуяа ардын хувьсгалын жилүүдэд голдуу бусад орноос хийсэн бэлэн зүйлийг авч ашиглаж сурсан хэв заншил юм. Үүн дээр «социалист том хүчирхэг Зөвлөлт Холбоот Улсад бүх материаллаг бүтээгдэхүүнийг бэлтгэн өгч байхад монгол мэт жижиг орон илүү зардал гаргаж цаг хугацаа алдаж өөрөө юм бүхнийг хийх гэж оролдох хэрэггүй гэдэг тэр үеийн монгол улсын засаг төрийн удирдагчдын «онол, сургаал» бас сүрхий их хүч нэмэр болж ирсэн юм.

6. Нийгмийн язгуур эрх ашгийн тусын төлөө биш хувийн явцуу, хэсэг бүлэг хүмүүсийн сонирхлын дагуу хэдхэн цөөхөн монголчууд дотроо хэсэг бүлэг болон ялгарч байх болсноор манай одоогийн шинэ ардчилсан хэмээгдэх үйлдвэрлэлийн харьцааны бас нэг зөрчил илэрч байна. Үүнд: орон нутгаар, яс үндсээр улс төрийн намуудаар, албан тушаалаар хэсэг бүлэг болон хуваагдах нь ялангуяа 1990-ээд оны улс төрийн үймээнээс хойш бүр ч их хүчтэй түргэн явцтай дэлгэрч түүнийгээ жинхэнэ ардчилал, хүний эрх чөлөө гэдгээр хөөрөгдөн магтаж байгаа нь бодит үндэсгүй зүйлээ. Ийм үзэгдэл нь манайд эх оронч үзэл дутмаг, нийгмийн ухааны ухамсар мэдлэг сул, зөвхөн хар амна бөөцийлөх оюун ухаан давамгайлж байгаагийн тод илрэл болох нь гарцаагүй.

7. Манай нийгмийн одоогийн үйлдвэрлэлийн харьцаанд их дэлгэрэнгүй ажиглагдах болж байгаа нэг сөрөг үзэгдэл бол хүнийг үнэлэн үзэж хүндэтгэх хүнлэг ёс дутагдаж зөвхөн албан тушаалыг эрхэмлэн дээдлэх болж байгаа явдал юм.

Үүний үндсэн шалтгаан нь урьдын засаг төрийн дарангуйлалын үед хэн илүү их дээгүүр хангамжтай өндөр албан тушаалд дэвшиж чадсан нь сайхан аж төрж байсан, мөн 1990 оноос өрнөсөн өндөр албан тушаал эзлэх гэсэн хувьсгалын мөн чанар манай үйлдвэрлэлийн харьцаанд нийм сөрөг нөлөөг бүр ч хүчтэй болгосон байна. Дээр тодорхойлсноос дүгнэж ойлгоход тус орны одоогийн үйлдвэрлэлийн харьцаа нь үйлдвэрлэх хүч, түүний гол шийдвэрлэх хэсэг-хүмүүсийн оюун ухаан сэтгэхүйг зохих ёсоор хөгжүүлэх хүчин зүйл болж чадахгүй харин түүнд сөрөг нөлөөг үзүүлэх болсон нь харагдаж байна.

II. Үйлдвэрлэлийн харьцааг боловсронгуй болгох асуудалд

1990-ээд онд эхэлсэн ардчилсан өөрчлөлтийн гол зорилго нь монгол улсын үйлдвэрлэлийн харьцаа үйлдвэрлэх хүчийг урамшуулагч хүч болгон шинэчлэн өөрчлөх асуудал байсан юм. Үүний учир нь 1990-ээд оны өмнөх монгол нийгмийн үйлдвэрлэлийн харьцаа нь дараах шинэ чанараар тодорхойлогдож байжээ. Үүнд:

1. Улс даяар эдийн засгийн асуудалд хүнд суртлын захиргаадан тулгах аппарат ноёрхсон.

2. Нэг намын удирдлага шууд засаг төрийн дарангуйлал болон хувирсан.

3. Бусад олон нийтийн байгууллага зөвхөн нэг намын удирдлагын диктатурыг хэрэгжүүлэгч болсон.

4. Ард түмний эрх чөлөө, ардчилал зөвхөн цаасан дээр тунхагласан ёс төдий баримт болсон.

5. Марксизмын бодит үнэн сургаалыг мушгин гуйвуулж үсэгчлэн цээжилж бурханчлан шүтэх үзэл суртал давамгайлсан.

6. Хууль цааз, дүрэм журам, ухуулга таниулга бүгдээр бусад орны ахуйн тусгалыг хуулбарласан, голдуу дууриамал баримт болсон.

7. Ард түмний хооронд ангиудын тус бүрийн эрх ашгаар ялгаварлагдсан харьцаа тогтносон.

8. Шинжлэх ухаан соёл боловсролын утга агуулга анги хэмээгчдийн явцуу эрх ашгийг баримталсан гарын авлага болж байсан.

9. Эх оронч үзэл бодлыг үндэсний дээрэнгүй үйл ажиллагаа гэж хавчин буруушаадаг болсон.

10. Монгол үндэсний эртний үе залгамжилсан эрхэм сайхан ёс заншил, өв уламжлалыг феодалын хоцрогдол гэнэ үгүйсгэн хориглодог болсон байв. Ийм ч учраас монгол улсын 1990-ээд оны үйлдвэрлэлийн харьцааг шинэчлэн боловсронгуй болгох асуудал манай эх орны цаг үеийн зайлшгүй шаардлага болсон байна.

1990-ээд оны ардчиллын нэрээр гарч ирсэн улс төрийн үймээн нь үйлдвэрлэлийн харьцааг шинэчлэн боловсронгуй болгох нь байтугай бүр өөр шинэ гүнзгий зөрчил, сөрөг шинжтэй болгосон юм. Ийм учраас үйлдвэрлэлийн харьцааныг одоогийн шинэ зөрчлийг дурдах нь чухал байна. Үүнд:

1. Эх орныг улс төр нийгмийн хувьд чиглүүлэгч намын удирдлагагүй болгосон.

2. Эх орны эдийн засгийн хөгжилд засаг төрийн зохицуулагч үүрэг биелэгдэхгүй болгосон.

3. Үндэсний нэгдмэл эдийн засгийг тарааж бутаргасан.

4. Жижиг хувийн өмч, дамын худалдааг нийгмийн гөллох хүч болгосон.

5. Хөдөлмөрийн түмэн олон «намуудаар» талцан сөргөлдөх болсон.

6. Улс орон маань ирээдүйд чухам ямар хөгжилд хүрэх тухай бодитой баримжаагүй болсон.

7. Нийгмийн хэмжээгээр эмх замбараагүй болж ёс суртахуун, хуульт ёс хөл дор гишгэгдэх болсон.

9. Ардын хувьсгалын жилүүдэд бүрэлдэн тогтнож хөгжин дээшилж байсан орчин цагийн шинжлэх ухаан соёл боловсролын системийг гадуурхан үйл ажиллагааг нь бууруулсан.

10. Хуучин ёс журмыг сэргээж байгаа нэрийдлээр манайд хоосон бишрэл, шүтлэг мэрэг таавар, дом төлөг зэрэг элдэв үнэн бодит биш, хүнийг мунхруулсан чиглэлтэй заншлыг өргөн дэлгэрүүлэх болж байна.

Одоо манай үйлдвэрлэлийн харьцааг боловсролгүй, дэвшингүй, ардчилсан шинж чанартай болгохын тулд тайван дөлгөөн замаар үндсэн шинэчлэлт өөрчлөлтийг хийх шаардлага гарч байна. Үүнд: Юуны өмнө: А. Нийгэм улс төрийн талаар дараах асуудалд анхаармаар бодогдож байна. 1. хэсэг бүлэг намууд хэмээгчийн нэрээр бус нийт ард түмний биеэр оролцдог шинэ маягийн үнэхээр ардчилсан сонгуулийн журамтай болгох,

2. Гадаад орны өөр ахуй амьдралын хуулбар, зөвхөн бэлэг тэмдэг болсон ерөнхийлөгчөөр толгойлуулсан төрт ёс мөн давхардсан үүрэг бүхий ёс төдий парламентын засаглал зэргийг өөрчлөн монголын өвөрмөц шинж бүхий жинхэнэ ажил хэрэгч төрийн хэлбэрийг тогтоох.

3. Хүн ам цөөнтэй, улс төр, нийгмийн тэмцэл мэдлэг бүрэн боловсролгүй болж гүйцээгүй монгол оронд улс төрийн олон намуудын асуудлыг зөвхөн эх орны нийтлэг эрх ашгийг эрхэмлэн шийдвэрлэж байх.

4. Одоогийн ор нэр болсон дууриамал ардчиллыг халж жинхэнэ ардын монгол ардчиллыг нэвтрүүлэх.

5. Нийгмийн амьдралын хөдөлгөөн бүхнийг дэглэхийг чармайсан үй түмэн хууль зааврыг компаничлан зохиох бус нийгэмд зайлшгүй ганц хэрэгцээнээс урган гардаг заавал биелэгддэг цогцолбор хуулийг боловсруулж хуулийн нэр хүндийг хамгаалах нь нэн чухал болсон байна.

6. Гадаад дотоодын цагаачлалын асуудлыг эх орон тусгаар тогтнол, төрийн бодлогын амин чухал асуудал болгож журамлах.

Б. Оюун ухааны талаар.

1. Тууштай түшиглэж баримтлах улс төрийн материалист үзэл суртлын чигийг боловсруулж хэрэгжүүлэх.

2. Соёл хүмүүжил, боловсролын бүтцийг сэргээн босгож цаг үеийн шаардлагад зохицуулан шинэчлэн өөрчлөн хөгжүүлэх,

3. Шинжлэх ухааныг эх орны ирээдүйн хөгжлийн хувь заяаг шийдвэрлэх хүчин зүйл болохыг онцлон анхаарч төрийн шинжлэх ухааны тодорхой бодлогыг боловсруулж мөрдөх.

4. Монгол үндэсний түүхэн үеийн өв уламжлалыг сэргээхдээ манай шинэ соёл иргэншилд тус нэмэр болохуйц аль дэвшилттэй бүхнийг сонгон авч үргэлжлүүлэн хослон хөгжүүлэх.

5. Олон ургальч үзэл маргааныг дэлгэрүүлэхдээ нийгмийн хүн амын давхаргуудын үзэл бодол, эв нэгдлийг задлахад хүргэх бус гагцхүү хүний оюун ухааныг хөгжүүлэх, жинхэнэ эх орны одоо ирээдүйн язгуур эрх ашгийн төлөө өрнүүлэх.

В. Эдийн засгийн талаар:

1. Үндэсний тусгаар тогтнолын ганц найдвартай баталгаа болох улсын өмчийг төр засаг бодлогын хэмжээгээр таваарын үйлдвэрлэлийн эдийн засгийн бодит хууль зүйн дагуу сэргээн хөгжүүлэх.

2. Пүүдлийн хувийн жижиг тархай бутархай мал аж ахуйтныг чөлөөт таваарын үйлдвэр-зах зээлийн харьцаанд шилжүүлэх гоц шалгарсан зам нь хоршооллын өмчийн хэлбэр болох учир түүний хөгжлийг дэмжиж засаг төрийн бодлого болгож дууриамал ардчилагчдын болчимгүй дайралтыг няцаах.

3. Хувийн өмчийн хөгжлийг өөгшүүлэхдээ материаллаг үйлдвэрлэлийг гол үндсэн чиглэл болгох.

4. Үйлдвэрийн багаж зэвсгийн үйлдвэргүйгээр улс орны тусгаар тогтнол гэж байдаггүй бөгөөд түүний үйлдвэрийг гагцхүү улсын өмч дээр л төлөвшүүлэх.

5. Ард түмний аж байдал, оюун ухааны ядуурлыг зогсоогоогүйгээр ирээдүйд шинэ шийгэмд шилжих, үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх үндэсгүй учраас үндэсний үйлдвэрийг хөгжүүлэх замаар ард түмний амьдралыг өөд татах асуудлыг төрийн нэн тэргүүний бодлого болгох.

6. Монгол орны нөхцөлд явагдах нээлттэй эдийн засгийн үзэл санааг тусгайлан боловсруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг ямар хэмжээгээр, аль салбарт яаж нэвтрүүлэх тухай засаг төрийн тусгай, тодорхой оновчтой эзэнтэй журмыг боловсруулж түргэн ажил хэрэг болгох.

7. Ард түмнийг дамын худалдааны монополь үнийн дарангуйллаас ангижруулах одоогийн манай хуурамч чөлөөт үнийн утга учрыг олон түмний өмнө илчлэх, жинхэнэ чөлөөт үнэний үйлчилгээг нэвтрүүлэхийн тул олон хэвшилт чөлөөт таваар үйлдвэрийг зах зээлийн үндэс болгох бодлогыг хэрэгжүүлэх.

8. Өмч хувьчлал хэмээгчээр гаргасан алдаа завхралыг засж түүгээр улс орны ард түмний өмч хөрөнгийг элдэв аргаар хувьдаа идэж завшигсдыг илрүүлж цээрлүүлэн улс орон ард түмнийг хохиролгүй болгох зэрэг нийгмийн амьдралын бүх салбарт тодорхой биет шинэчлэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхгүйгээр үйлдвэрлэлийн харьцааг боловсронгуй болгож эх орноо энэхүү аюулт хямралаас гаргаж түүний тусгаар тогтнолыг хамгаалж чадахгүй билээ. Үйлдвэрлэлийн харьцааг боловсронгуй болгох асуудлыг юу юунаас өмнө Монгол улсын одоогийн нийгмийн харьцааг тал бүрээс нь иж бүрэн судлах явдлаас эхлэх хэрэгтэй юм.